



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/122

Улаанбаатар хот

Г
Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ
байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих,
гэрээг сунгах, дуусгавар болгох журмыг
батлах тухай

Монгол Улсын Засгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам"-ыг нэгдүгээр, "Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гэрээний загвар"-ыг хоёрдугаар, "Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт"-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга наарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал)-т, Санхүү, эдийн засгийн газар (Л.Лувсан)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дүгээр сарын 22-ны өдрийн А/104 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.



С.ЧИНЗОРИГ

141240545

Эрүүл мэндийн сайдын 2024 оны ...
дугаар сарын 12 өдрийн 12 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ, ХЯНАЛТ ТАВИХ, ГЭРЭЭГ СУНГАХ, ДУУСГАВАР БОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь төрөөс хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий өрхийн эрүүл мэндийн төв (цаашид төв гэх)-тэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгоходоо ил тод, нээлттэй, нотолгоо, тоон мэдээлэлд үндэслэн шударга үнэлж, аливаа хөндлөнгийн нөлөөллөөс ангид хараат бус байх зарчмыг мөрдөнө.

1.3. Гэрээний захиалагч тал нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, гүйцэтгэгч тал нь Өрхийн эрүүл мэндийн төв байх бөгөөд гэрээг Аймаг, нийслэлийн Засаг дарга батална.

1.4. Төвтэй байгуулах гэрээний салшгүй хэсэг нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт байна.

1.5. Аймаг, Нийслэлийн Засаг дарга захирамж гарган үнэлгээний багийг томилон гэрээний хэрэгжилтийг дүгнэнэ.

Хоёр. Гэрээ байгуулах

2.1. Төвийн өмнөх жилийн үнэлгээний дүнг үндэслэн гэрээг захиалагч, гүйцэтгэгч талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр тухайн жилийн 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор байгуулна.

2.2. Төвтэй байгуулах гэрээний гүйцэтгэлийг үнэлэхдээ Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан "Өрх, сум, тосгоны зруул мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, жагсаалт, гүйцэтгэлийг үзүүлэлтийг шинэчлэн батлах тухай" тушаалд заасан шалгуур үзүүлэлтийг баримтална.

2.3. Гэрээнд дараах асуудлуудыг тусгасан байна.

2.3.1. Оролцогч талуудын эрх, үүрэг

2.3.2. Гэрээний хугацаа

2.3.3. Гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд, нэмэлт үзүүлэлтүүд

2.3.4. Тайллагнах

2.3.5. Гэрээ дүгнэх

- 2.3.6. Гэрээ цуцлах
- 2.3.7. Маргаан шийдвэрлэх
- 2.3.8. Бусад

2.4. Гэрээг 3 хувь үйлдэж, талууд гарын үсэг зурснаар хучин төгөлдөр болно.

2.5. Талууд гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилсэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэхийг хориглоно.

2.6. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн хохирлыг үүргээ биелүүлээгүй тал бүрэн хариуцна.

2.7. Жилийн үнэлгээгээр “Хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн төвтэй нэг жилээр байгуулна.

2.8. Жилийн үнэлгээгээр “Хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдсэн төвтэй гэрээг цуцална.

2.9. Тухайн жилийн 7 дугаар сарын хагас жилийн үнэлгээгээр хангалтгүй үнэлгэдсэн Өрхийн эрүүл мэндийн төвийн даргыг чөлөөлж нөхөрлөлийн хурлаар дараагийн шинэ даргыг томилно.

Гурав. Гэрээг дүгнэх

3.1. Гэрээний хэрэгжилтийг жилд 2 удаа тухайн жилийн долоодугаар сар, дараа жилийн 1 дүгээр сарын 05-ны өдрийн дотор дүгнэж дүгнэлт, зөвлөмжийг гэрээ байгуулсан талуудад хүргэнэ.

3.2. Гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ ажлын байран дээр, ил тод, шударга, нээлттэй зарчмыг баримтлан тэгш эрхтэй оролцон дүгнэж, үнэлгээний багийн болон өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар үнэлгээний хуудсанд гарын үсэг зурснаар баталгаажна.

3.3. Гэрээний хэрэгжилтийн гүйцэтгэлийн үнэлгээг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Өрхийн эрүүл мэндийн төв нь 2 хоногийн дотор гомдол гаргана.

3.4. Гомдол гаргасан тохиолдолд аймаг /сум/-ын засаг дарга, нийслэлд нийслэл /дүүрэг/-ийн засаг дарга үнэлгээний багийг дахин 1 удаа 5 хоногийн дотор томилно.

3.5. Томилогдсон үнэлгээний баг ажлын 5 хоногийн дотор үнэлж дүгнэлтийг аймаг /сум/-ын засаг дарга, нийслэлд нийслэл /дүүрэг/-ийн засаг даргад хүргүүлнэ.

3.6. Гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд хамаарахгүй баримт бичиг, бусад материалыг өрхийн эрүүл мэндийн төвөөс шаардахыг хориглоно.

3.7. Гэрээний гүйцэтгэл, үр дүнг харьялах нутаг дэвсгэрийн хүн амд танилцуулна.

Дөрөв. Үнэлгээний баг ажиллуулах

4.1. Үнэлгээний багийн гишүүдийг аймаг /сум/-ын засаг дарга, нийслэлд нийслэл /дүүрэг/-ийн засаг дарга захирамж гарган томилно.

4.2. Үнэлгээний баг нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй дараах албан тушаалтны төлөөлөлтэй байна. Үүнд:

- 4.2.1. Үнэлгээний багийн дарга: Аймаг, нийслэлийн /сум, дүүргийн/ Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- 4.2.2. Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга: Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний асуудал хариуцсан нэгжийн дарга

4.2.3. Гишүүд:

- 4.2.3.1 Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвийн анхан шатны тусlamж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- 4.2.3.2 Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвийн тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- 4.2.3.3 Эрүүл мэндийн газрын, эрүүл мэндийн төвийн статистикийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- 4.2.3.4 Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо болон бусад төрийн бус байгууллага
- 4.2.3.5 Харьяаллын иргэний төлөөлөл

4.3. Томилогдсон үнэлгээний баг гэрээний хэрэгжилтийг дүгнэх хуваарийг тухайн жилийн арван хоёрдугаар сарын 20-нд өрхийн эрүүл мэндийн төвд мэдэгдэнэ.

Тав. Гэрээг дуусгавар болгох

- 5.1. Гэрээний хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн төвийн гэрээг дуусгавар болгох эсэхийг дор дурдсан байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 5.1.1. Бүтэн жилийн буюу дараа оны 1 дүгээр сарын үнэлгээгээр “хангалтгүй” үнэлгээ авсан;
 - 5.1.2. Гэрээнд заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзсан;
 - 5.1.3. Эмчилгээ, үйлчилгээний ноцтой доголдол гаргаж, иргэний эрүүл мэндэд хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;
 - 5.1.4. Хөрөнгө, санхүү, үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж зөрчсөн нь нотлогдсон;
 - 5.1.5. Төрийн болон орон нутгийн өмчийг шамшигдуулсан.

5.2. Гэрээг цуцалсан тохиолдолд холбогдох тушаал, шийдвэрийн дагуу дараагийн төвийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах хүртэлх хугацаанд тусlamж, үйлчилгээг тасралтгүй явуулах үүргийг урьд гэрээтэй байсан өрхийн эрүүл мэндийн төв гүйцэтгэнэ.

Зургаа. Гэрээг дүгнэх аргачлал

6.1. Гэрээний хэрэгжилтийг энэхүү тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

6.2. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь:

- 6.2.1. өвөрмөц шалгуур
- 6.2.2. тусlamж, үйлчилгээний үндсэн үзүүлэлт
- 6.2.3. нийтлэг шалгуур үзүүлэлт
- 6.2.4. дээд шатны байгууллагын үнэлгээнээс бүрдэнэ.

6.3. “Өвөрмөц шалгуур үзүүлэлт”-ийг “Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусlamж, үйлчилгээний журам, жагсаалт”-ын дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас дүгнэсэн тусlamж, үйлчилгээний чанар, үр дүнгийн үнэлгээгээр үнэлэх ба нийт үнэлгээний 55 хүртэлх хувийг эзэлнэ.

6.4. “Тусlamж, үйлчилгээний үндсэн үзүүлэлт”-ийг статистик мэдээ тайлан, үнэлгээний багийн дүнгээр үнэлэх ба нийт үнэлгээний 20 хүртэлх хувийг эзэлнэ.

6.5. “Нийтлэг шалгуур үзүүлэлт”-ийг төвийн удирдлага, манлайлал, тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, үндсэн үзүүлэлт, санхүү төсөв, хөрөнгө хамгаалал зэрэг шалгуураар үнэлэх ба нийт үнэлгээний 20 хүртэлх хувийг эзэлнэ.

6.6. “Дээд шатны байгууллагын үнэлгээ” Нийслэлийн эрүүл мэндийн газар, салбарын хяналтын газар болон бусад төрийн байгууллагын төлөвлөгөөт болон онцгойлон сайн гэж үнэлэгдсэн тохиолдолд үндсэн үнэлгээний 100 оноос гадна нэмэлтээр 5 хүртэлх оноогоор үнэлнэ.

6.7. Нэмэлт үзүүлэлт нь энэхүү тушаалыг гуравдугаар хавсралтын Хүснэгт 4-т заасан шалгуурт тухайн Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг онцгойлон сайн гэж үнэлэгдсэн тохиолдолд үндсэн үнэлгээний 100 оноос гадна нэмэлтээр 5 хүртэлх оноогоор үнэлнэ.

6.8. Гэрээний хэрэгжилтийг дараах 2 хэлбэрээр дүгнэнэ.

- 6.8.1. Цахим
- 6.8.2. Ажлын байранд үнэлсэн үнэлгээ

- 6.9. Хэрэгжилтийг үнэлэхдээ 100 хувийн үнэлгээний дунгээр үнэлнэ. Үүнд:
- 6.9.1. Өвөрмөц шалгуур 55 хувь байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас дүгнэсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн 80 ба түүнээс дээш хувиар үнэлгэдсэн тохиолдолд 80 оноо буюу 55 хувь,
 - 6.9.2. Тусламж, үйлчилгээний үндсэн үзүүлэлт 20 оноо буюу 20 хувь,
 - 6.9.3. Нийтлэг шалгуур 20 оноо буюу 20 хувь,
 - 6.9.4. Дээд шатны байгууллагын үнэлгээ 5 оноо буюу 5 хувь гэж тус тус тооцно.
- 6.10. Шалгуур үзүүлэлт тус бүр ногдсон оноотой байна.
- 6.10.1. Шалгуур үзүүлэлт бүрийн нийлбэр оноогоор бүлэг бүрийн нийлбэр онооны дүн гарна.
 - 6.10.2. Шалгуурт бүрэн нийцсэн бол зөвхөн бүтэн оноо өгнө. Оноог хагаслаж өгөхгүй.
 - 6.10.3. Бүлэг бүрийн онооны нийлбэрээр гүйцэтгэлийн хэрэгжилтийн нийт оноо /өрөнхий дүн/ гарна.
- 6.11. Хагас бүтэн жилийн үнэлгээний нийлбэрийн дундаж үзүүлэлтээр тухайн Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэн жилийн үнэлгээний дүн гарна.
- 6.12. Гэрээний хэрэгжилтийн ерөнхий дүн 80,0 хувь ба түүнээс дээш бол “Хангалттай”, 79,0 хувь ба түүнээс доош бол “Хангалтгүй” гэж тооцно.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15. өдрийн 12 дугаар тушаалтын хоёрдугаар хавсралт

БАТЛАВ.

АЙМАГ/сум/, НИЙСЛЭЛ
/дүүрэг/ -ИЙН ЗАСАГ
ДАРГА

/гарын үсэг, тамга/

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Дугаар.....

20... он.... сар....өдөрхот

Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэг, 343 дугаар зүйлийн 343.1 дэх хэсэг, Нөхөрлөлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2 дахь заалт, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 17 дугаар зүйлийн 17.1 дэх, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 10.2, 9.1.9 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн;

Нэг талаас /цаашид захиалагч гэх/ Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн төвийн дарга "....." харьялах нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээг сайжруулах, салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих"

Нэгөө талаас /цаашид гүйцэтгэгч гэх/ нар харьялах Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар харьялах нутаг дэвсгэрийн ёрх бурд эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээг чанар, хүртээмжтэй, чирэгдэлгүй үзүүлэх зарчмыг баримтлан харилцан тохиролцож 20.... оны сарын-ны өдөр энэхүү гэрээг / цаашид "гэрээ" гэх/ байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь: "....." Өрхийн эрүүл мэндийн төв /цаашид төв гэх/ -өөс харьялах нутаг дэвсгэрийн хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны цогц тусlamж, үйлчилгээг чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

- 1.2. Гэрээний салшгүй хэсэг нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт байна.
- 1.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн биелүүлэх талаар харилцан шаардлага тавих, үүргээ биелүүлэхгүй нөхцөлд хариуцлага хүлээх асуудлаар тэгш эрх эдэлнэ.

Хоёр. Гэрээний хугацаа, хэрэгжилт

- 2.1.“Хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн төвтэй нэг жилээр гэрээг байгуулна.
- 2.2.Гэрээг тухайн оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор байгуулна.
- 2.3.Гэрээний хэрэгжилтийг жилд 2 удаа тухайн жилийн долоодугаар сар, дараа жилийн 1 дүгээр сарын 05-ны өдрийн дотор үнэлнэ.

**Гурав. Өрхийн эрүүл мэндийн төвөөс гэрээний хүрээнд
үзүүлэх тусlamж, үйлчилгээ**

- 3.1. Төв нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусlamж, үйлчилгээний журам, жагсаалт, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлах тухай” тушаалд заасан тусlamж, үйлчилгээг үзүүлнэ.

**Дөрөв. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын
даргын үүрэг, эрх**

- 4.1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 4.1.1. Төвийг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангаж, бие даан ажиллах боломж нөхцөлийг бурдүүлэх;
 - 4.1.2. Төвд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 4.1.3. Төвийн үйл ажиллагаатай холбоотой иргэн, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шуурхай барагдуулж, эргэн мэдээлэх;
 - 4.1.4. Төвийн эмч, мэргэжилтнүүдийг цаг үеийн болон мэргэжлийн холбогдолтой мэдээллээр тогтмол хангаж ажиллах;
 - 4.1.5. Төвийг эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, оношуураар хангахад дэмжлэг үзүүлэх;
 - 4.1.6. Төвд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл тусlamжид хамруулах, төсөвт тусган, захиалж хангах;
 - 4.1.7. Төвийн эмч мэргэжилтнүүдэд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;
 - 4.1.8. Мэргэжлийн хяналт, Эрүүл мэндийн даатгалын болон бусад байгууллагаас ирүүлсэн акт, шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
 - 4.1.9. Төвийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгээс хамааран шагнал урамшуулал олгох, холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх.

4.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нь дараах эрхийг эдэлнэ.Үүнд:

4.2.1. Иргэдэд чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй тусlamж, үйлчилгээг үзүүлэх талаар төвд шаардлага тавих;

4.2.2. Жирэмсэн эх, нярай хүүхэд, 65-с дээш насны ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэрийн эргэлтээр хянах;

4.2.3. Төвөөс иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулах, эрүүл мэндийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах үйл ажиллагааг зохицуулах;

4.2.4. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, гамшиг, осол, нийтийг хамарсан халдварт өвчний үед холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулах;

4.2.5. Төвийн үйл ажиллагаатай холбоотой иргэний өргөдөл, гомдлын мөрөөр хяналт, шалгалт хийх;

4.2.6. Мэргэжлийн хяналт, Эрүүл мэндийн даатгалын болон бусад байгууллагаас ирүүлсэн акт, шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар шаардлага тавих.

Тав. Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын үүрэг, эрх

5.1. Төвийн дарга нь дараах үүргийг хүлээнэ.Үүнд:

5.1.1. Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, бусад тогтоомж, тушаал, Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм, стандартад заасан үүргийг хүлээж ажиллах;

5.1.2. Тусlamж, үйлчилгээг чанар, хүртээмжтэй, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор хүний нөөцийг бүрдүүлж, өрх бүрд хүрч ажиллах нөхцөлийг ханган зохион байгуулах;

5.1.3. Хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, дадлагажуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх цогц төлөвлөгөө хэрэгжүүлж, ажлын байрны эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, төвийн эмч, ажилтнуудын нийтлэг эрх ашгийг хамгаалах;

5.1.4. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, мэргэжлийн үүргийг чанд биелүүлж, хамт олон, баг бүрдүүлж ажиллах;

5.1.5. Үйлчлэх хүрээний айл өрхийг эрүүл мэндийн байдлаар 3, хүн амыг эрүүл мэндийн байдлаар 5 бүлгээр ангилан, бүлэг бүрд тусгайлан чиглэсэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавьж үр дүнг тооцох;

5.1.6. Төвийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бусад материалыар хангах;

5.1.7. Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлсийг судлах, арилгах талаар шийдвэр гаргах түвшинд асуудал тавих, шийдвэрлүүлэх;

5.1.8. Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих

асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

5.1.9. Эрүүл мэндийн цахим системийг ашиглах, мэдээ, мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргахад ашиглах, шаардлагатай үнэн бодит мэдээллийг холбогдох байгууллагад тухай бүр хугацаанд нь илгээх;

5.1.10. Төсөв санхүүгийн холбогдох хууль, дүрэм, журмыг чанд сахиж, санхүү хөрөнгийг оновчтой, зөв зарцуулж, хамт олон, иргэдэд нээлттэй мэдээлэх;

5.1.11. Төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах, үйлчлэх хүрээний хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тулгамдсан асуудлаа холбогдох байгууллагад тухай бүр тавьж шийдвэрлүүлэх;

5.1.12. Үйлчлүүлэгчийн мэдээлэл хайх, хүлээн авах, эмчээ сонгох эрхийг ханган эмч, эмнэлгийн мэргэжилтүүдийн мэдээллийг ил тод байршуулах.

5.1.13. Тусlamж үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн олгож буй санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах, өр үүсгэхгүй байх;

5.1.14. Төвийн эд, хөрөнгийг ариг гамтай ашиглахад хяналт тавих, өөр байгуулагад шилжүүлсэн, үрэгдүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээх, нөхөн төлөх.

5.2. Төвийн дарга нь дараах эрхийг эдэлнэ.

5.2.1 Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох, хууль тогтоомж, эрхийн эрүүл мэндийн төвийн дүрэмд заасан эрхийг эдлэх,

5.2.2 Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, дүрэм, тушаалыг зөрчсөн аливаа асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх,

5.2.3 Бусад талуудыг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах,

5.2.4 Батлагдсан төсвийг нөхөрлөлийн гишүүдийн хурлыг шийдвэрээр зөв зохистой зарцуулах,

5.2.5 Тусlamж, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжилтийг бүрэн авах.

Зургаа. Тайлагнах

6.1. Төв нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болон гэрээний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гарган аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

6.2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан анхан шатны эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний багц, түүний санхүүжилт, хяналттай холбоотой тогтоол, шийдвэрт заасан шаардлагын дагуу холбогдох газарт нь тайлagnана.

Долоо. Гэрээг цуцлах

7.1. Гэрээг дараах тохиолдолд цуцална

7.1.1. Гэрээгээр хүлээсэн чиг үүргээ "Хангалтгүй" биелүүлсэн,

7.1.2. Төв нь гэрээнд заасан ажил үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзсан,

7.1.3. Эмчилгээ, үйлчилгээний ноцтой доголдол гаргаж, иргэний эрүүл мэндэд хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон,

7.1.4. Хөрөнгө, санхүү, үйл ажиллагааны талаарх хууль тогтоомжийн ноцтой зөрчил гаргасан нь шалгалтаар илэрсэн,

7.1.5. Төрийн болон орон нутгийн өмчийг шамшигдуулсан,

7.2. Гэрээ цуцлагдан дараагийн өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах хүртэлх хугацаанд гэрээ нь цуцлагдаж буй төв иргэдэд тусламж, үйлчилгээ тасралтгүй үзүүлэх үүргийг хүлээнэ.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1. Энэ гэрээнд заагдаагүй аливаа асуудлыг Монгол улсад дагаж мөрдөж буй хууль, тогтоомжоор зохицуулна.

8.2. Гэрээний хэрэгжилтийн гүйцэтгэлийн үнэлгээг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Өрхийн эрүүл мэндийн төв нь 2 хоногийн дотор гомдол гаргана.

8.3. Гомдол гаргасан тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга үнэлгээний багийг дахин 1 удаа 5 хоногийн дотор томилно.

8.4. Томилогдсон үнэлгээний баг ажлын 5 хоногийн дотор үнэлж, дүгнэлт гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад хургуулнэ.

8.5. Дахин томилогдсон үнэлгээний багийн дүгнэлтийг хүчин төгөлдөрт тооцно.

8.6. Гэрээтэй холбоотой маргааныг талууд ойлголцож, харилцан тохиролцох замаар шийдвэрлэж болно.

Ес. Бусад зүйл

9.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талын албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчлэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэхийг хориглоно.

9.2. Гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох, хэрэгжилттэй холбоотой бусад асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

9.3. Гэрээг жил бүрийн 01 дүгээр сард батааж гэрээ байгуулна, 3 хувь үйлдэнэ.

ЗАХИАЛАГЧ:

**АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА**

ГҮЙЦЭТГЭГЧ:

**ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА**

/гарын үсэг, тамга/

/гарын үсэг, тамга/



ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Тусламж, Үйлчилгээний Үндсэн Үзүүлэлт

ДД	Шалгуйр Үзүүлэлт	Үр дүн	Авбал зохих оноо	ABCAN OHOO	Laxnm	ҮHARTEEL Nn Gar	Гэрээ дүгнэх хэлбэр	Мэдээллийн эх сурвалж
Наг. Хүүхдийн хяналт								
1.	Цус багадалт	Эрт илрүүлэг, Узлаг шинжилгээгээр шинээр цус багадалтай илэрсэн хүүхдийн тоо	4			✓	Үнэлгээний аргаар 10 хүүхдийн дэвтрээс шүүж үзэхэд 100% нотлогдсон тохиолдолд авах ёстой бүх оноог хасна)	Түүврийн баг санамсаргүй түүврийн мэндийн эрүүл мэндийн 100% нотлогдсонон тохиолдолд нотлогдоогүй авах ёстой баг санамсаргүй түүврийн мэндийн эрүүл мэндийн 100% нотлогдсонон тохиолдолд авах ёстой бүх оноог хасна)
2.	Тураалт	Эрт илрүүлэг, Узлаг шинжилгээгээр шинээр тураллтай илэрсэн хүүхдийн тоо	4			✓	Үнэлгээний аргаар 10 хүүхдийн дэвтрээс шүүж үзэхэд 100% нотлогдсон байх (1 тохиолдолд нотлогдоогүй авах ёстой бүх оноог хасна)	Үнэлгээний аргаар 10 хүүхдийн дэвтрээс шүүж үзэхэд 100% нотлогдсон байх (1 тохиолдолд нотлогдоогүй авах ёстой бүх оноог хасна)
3.	Илгүүдэл жин	Эрт илрүүлэг, Узлаг шинжилгээгээр шинээр илгүүдэл жинтэй илэрсэн хүүхдийн тоо	4			✓	Үнэлгээний аргаар 10 хүүхдийн дэвтрээс шүүж үзэхэд 100% нотлогдсон байх (1 тохиолдолд нотлогдоогүй авах ёстой бүх оноог хасна)	Үнэлгээний аргаар 10 хүүхдийн дэвтрээс шүүж үзэхэд 100% нотлогдсон байх (1 тохиолдолд нотлогдоогүй авах ёстой бүх оноог хасна)
4.	Стрептококкын халдварын илрүүлэх халдварын илрүүлэг	Стрептококкын халдварын илрүүлэх узлаг шинжилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	4			✓	Үнэлгээний аргаар 10 хүүхдийн дэвтрээс шүүж үзэхэд 100% нотлогдсон байх (1 тохиолдолд нотлогдоогүй авах ёстой бүх оноог хасна)	Үнэлгээний аргаар 10 хүүхдийн дэвтрээс шүүж үзэхэд 100% нотлогдсон байх (1 тохиолдолд нотлогдоогүй авах ёстой бүх оноог хасна)

Хоёр. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үндсэн үзүүлэлт

5.	Эхийн эндэгдэл	Эхийн эндэгдэл ӨЭМТ-ийн үйл ажиллагаанас шалтгаалсан бол	-4	✓	✓		Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик үзүүлэлтээс авна (урьдчилан)
6.	0-5 наасны хүүхдийн эндэгдэл	0-5 наасны хүүхдийн эндэгдэл ӨЭМТ-ийн үйл ажиллагаанаас шалтгаалсан бол (осоп, гэмтгээс бусад шалтгаант)	-4	✓	✓		Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик үзүүлэлтээс авна
7.	Хүн амын нийт нас баралтын тоо	Хүн амын нийт нас баралтын тоо	-4	✓	✓		Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик үзүүлэлтээс авна
8.	Хяналтгүй төрөлт	Харьялах хүн амын дунд гарийн шалтгаалсан бол	-4	✓	✓		Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик үзүүлэлтээс авна
Гурав. Эрсдэлт булгийн хүн амын үндсэн үзүүлэлт							
9.	Хяналтад ороогүй тархины цус харвалтын шалтгаант нас баралт	Хяналтад ороогүй тархины цус харвалтын шалтгаант нас баралтын тохиолдол илэрсэн бол	-3	✓	✓		Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик үзүүлэлтээс авна
10.	Хяналтад ороогүй зүрхний шигдээсийн шалтгаант нас баралт	Хяналтад ороогүй зүрхний шигдээсийн шалтгаант нас баралтын тохиолдол илэрсэн бол	-3	✓	✓		Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик үзүүлэлтээс авна
11.	Хяналтад ороогүй шижингийн хүндэрэл (бөөрний дугаадал, цус харвалт, хөл тайрах мэс засал) илэрсэн баралт	Хяналтад ороогүй шижингийн хүндэрэл (бөөрний дугаадал, цус харвалт, хөл тайрах мэс засал) илэрсэн бол	-3	✓	✓		Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик үзүүлэлтээс авна
Дөрөв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, үйлчилгээний үнэлгээ							
12.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хяналт	Харьяаллын хүн амын нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэнийт жилд 2 удаа 100% хянасан байх	2	✓	✓		Эрүүл мэндийн дэвтэрээр 100% нотлогдсон байх
13.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлгөөн хийх зөвлөөөг өгөх	Харьяаллын хүн амын нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэнийт жилд 2 удаа 100% зөвлөөг өгсөн байх	1	✓	✓		Эрүүл мэндийн дэвтэрээр 100% нотлогдсон байх
14.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлсэн байх	Харьяаллын хүн амын нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 80-аас доошигийн сэргээн засах тусlamж, хувьд үйлчилгээ үзүүлсэн байх	1	✓	✓		Эрүүл мэндийн программыг ашиглан
Булгийн нийт оноо (B) = (Авсан "+" оноо) - (Авсан "-" оноо)						20	Цахим

Хүснэгт 2. Нийтлэг шалгуур үзүүлэлт

№/Д	Шалгуур үзүүлэлт	Үр дүн	Авбал зохих оноо	ABCASH OHOО Laxnm	Гэрээ дүгнэх хэлбэр	Гэрээ дүгнэх хэлбэр	Мэдээллийн эх сурвалж	
							ABCASH OHOО Laxnm	YHCHGEL Gar HIN
Нэг. Төвийн даргын дэмжигэгт удирдлага, манайпал								
1.	Нөхөнөлөл байгуулсан гэрээ, гэрээний хэрэгжилт	Гэрээний хэрэгжилтийн хувь 80%-иас дээш байх			1		• Гэрээнд шалгуур үнэлгээ, үнэлж аргачлал, үзүүлэх үйлчилгээ тусгасан байх	
2.	Нөхөрлөлийн хамрагдсан мэргэжилтийн хувь	Гишүүнд эмнэлгийн 70% иас доошгүй Эмч, мэргэжилтийн 70% иас доошгүй хамруулсан байх байна.			1	✓	• Гэрээний хэрэгжилтийг хэрэгжилтийн тайлан	
3.	ӨЭМТ-ийн хэрэгжилт	Дурмийн 80%-иас доошгүй байх			1	✓	Улсын бүртгэлийн өрөөний газар https://burtgel.gov.mn	
4.	Мэдээллийн нэгдмэл байдал	Сангийн Төвийн хариуцсан байршилын хувь амын жагсаалт файллаар байх			2	✓	• Харьяалал хүрээний хүн амын нэдсэн бургтэл	
Хоёр. Иргэдийн сэтгэл ханамжийн байдал								
5.	Ёс зүйн байх	Зерчил гаргаагүй			1	✓	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын ёс зүйн салбар хороондын тодорхойлолтоор үнэлнэ	
6.	Хамт олны ханамжийн хувь	Сэтгэл			0,5	✓	• Үнэлгээний баг явцын болон жилийн эцсийн үнэлгээгээр ажилнуудаас үнэлгээ авч үнэлнэ	
						✓	• ЭМТҮЧДБЫН багийн авсан үнэлгээ	

7.	Үйлчилгээний хувь, ханамжийн мөрөөр хэрэгжүүлсэн хэмжээний хэрэгжилт	сэтгэл сэтгэл судалгааны мөрөөр ханамжийн хэрэгжүүлсэн арга ханамжийн хэрэгжилт	Үнэлгээ өгсөн үйлчилгээний тоо нийт ирж үйлчилгээний тоо хувиас доошгүй байх Үнэлгээ өгсөн иргэдийн доошгүй 50 хувиас үзүүлсэн байх	0,5	✓		1313.тп Статистик мэдээллийн сангаас авна
8.			Сэтгэл ханамжийн иргэдийн буртгэл, түүний хийсэн арга ханамжийн төлөвлөгөө, тайлантай байх		✓	Сэтгэл ханамжийн буртгэсэн иргэдийн буртгэл, түүний мөрөөр хийсэн арга ханамжийн төлөвлөгөө, тайлантай байх	Судалгаанд төлөвлөгөө, тайлан
9.	Хүний суурьшил	Ноөцийн тогтвор	Стандартад заасан орон тоогоор ажиллаж байгаа бол	1	✓	https://www.ndaatgal.mn/	Нийтийн даатгалын цахим программаас харна
10.			З-с дээш жил ажилласан ажилчдын хувь 60%-с дээш байх		✓		
11.	Өрхийн анаагаах ухаан болон мэргэшсэн байх мэргэшсэн эмнэлгийн мэргэжлийн зээлэх хувь	Бусад нарийн мэргэжлээр эмнэлгийн мэргэжлийн зээлэх хувь	Эмнэлгийн мэргэжлийн >50% нь мэргэшсэн байх батц Цагийн сургалтад хамраадсан байх	1	✓	https://hdc.gov.mn/	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хүний ноөцийн мэдээллийн сангаас харна.
12.	Санхүүгийн ил тод байдал	Санхүүгийн нээлттэй байх	Санхүүгийн цахим тайлан мэдээ	1	✓	https://shilendans.gov.mn/	
13.	Хүний ноөцийн ил тод байдал	Хүний ноөцийн мэдээлэл иргэд, байгууллагуудад харилцач нээлттэй байх		1	✓	1313.тп - Статистик мэдээллийн санч, мэдээлэл бурзен орсон байгааг дүгнэнэ.	
Дөрөв. Нээлттэй ил тод байдал							
14.	Эмнэлгийн үйлчилгээтэй тохиолдол, эрсдэлд дун шинжилгээ хийж мэдээлсэн байдал	Туслаамж, холбоотой холбоотой тохиолдол, ЭТУ-тэй эрсдэлийн тоо	Мэдээний нэгдсэн санд буртгэсэн ЭТУ-тэй холбоотой тохиолдол,	1	✓	http://www.eburtgel.mn.gov.mn/	
15.	ХСХ-ын төлөвлөгөөний биелэлтийн хувь			0,2	✓	ЭМ-ийн сайдын А/536, 537, 538, 539 тушаал	
16.	Эрүүл мэндийн ажилтнуудыг халдуураас сэргийлэх			0,2	✓		

Тав. Туслаамж, Үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдуурааны сэргийлэлт, хяналт

	сургалт зохион байгуулсан байдал	• Тушаал журам, зааврын дагуу арга хэмжээ авсан бүртгэл.				
17.	Эрүүл мэндийн ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэг, дархлаажуулалт хийсэн байх, өртөлөөс сэргийлэх арга хэмжээ	• Гэрээний хэрэгжилтийн тайлан гаргасан байна.	0,2			✓
18.	Давтан хэрэглэдэг багаж, хэрэгслийн ариутгалын үйл ажиллагааны хэрэгжилт		0,2			✓
19.	Эрүүл мэндийн ажилтнуудын гарын эрүүл ахуй сахих нөхцөл бурдуулсан эсэх ахуй сахих	Гарын эрүүл ахуй сахих орчныг жurmын дагуу бурдуулсан заасан	0,2			✓
20.	ЭТҮХХ-ыг илрүүлэх тандант хийсэн тоо, идэвхтэй, идэхгүй тандалтын мэдээ	Журам, тандалтуудыг хийж, илрүүлж бүртгэж мэдээлдэг, хариу арга хэмжээ авсан бүртгэл	заасарт халдварт хийж, мэдээлдэг, хариу 1			✓
21.	Аюултай хог хаягдлын, менежментийн үйл устгал, менежментийн үйл ажиллагаа	Аюултай хог менежментийн тайлан хэрэгжилтийн тайлан Гэрээтай	хаягдлын төлөвлөгөөний 0,5			✓
Зургаа. Тоног төхөөрөмж						
22.	Стандартад заасан тоног төхөөрөмжөөр хангадсан хувь	Стандартад заасан тоног төхөөрөмжөөр баталгаажжиттэй >80%-д бий	тоног хангаж, >80%-д хүргэсэн	0,5		✓
23.	Тоног төхөөрөмжийн засвар үйчилгээ, баталгаажилтад хамрагдсан хувь	Шалгалт тохируулгын үр дүнгийн хуудас, Тоног төхөөрөмжийн техник үйлчилгээний хуудас	тоног хангаж, баталгаажилтад хамрагдсан хувь	0,5		✓
Долоо. Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт						
24.	Нэг иргэнд ногдох санхүүжилтийн зарцуулалт	Батлагдсан төсөвт багтаан орон тоо, ажиллагаадын цалин тогтоосон байна.	тонон хөлсийг	1		✓
25.	Төсвийн мэдээг гаргасан тоо (ТГ-4 маягт), (өглийн авлагын хамаарч үнэлэх)	Гүйцэтгэлийн хугацаанд нь зарцуулж, өглийн авлага	зориулалтын дагуу үүсгээгүй ажилласан байна.	0,5		✓
Төсвийн хуваарь, нөхөрлөлийн хурлын шийдвэр						
						Төсвийн хуваарь, нөхөрлөлийн хурлын шийдвэр
						Тайлан, мэдээ, ТГ-4 маягт

26.	Аудитэд хамруулж дүгнэлт гаруулсан байх	Зөрчилгүй санал дүгнэлт байна	0,5	✓		
27.	Хуулийн хэрэгжилтийн хувь, (Санхүүгийн тайланг улирал бүр гаргасан байх)	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байх	0.5	✓		шиллэн ДАНС https://shilendans.gov.mn/
28.	Хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр ангилж бүртгэсэн хувь	Хөрөнгө оруулалтаар ирж буй хөрөнгийн бургтээлд НББ-ын тухай хуулийн дагуу 100% тусгаж ажилласан байх /Улаан төсвийн болон гадаадын зээл тусlamж, хувь хүний хандив, орон нутгийн эх үүсвэр/	1	✓		
29.	Хагас жилийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь 90%-иас дээш байх	1	✓		Хэрэгжилтийн хувиар тооцох
Бүлгийн нийт оноо (С)		20				

Хүснэгт 3. Дээд шатны байгууллагын явцын үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ

Хяналт, үнэлгээ		Шалгур	Авч болох оноо	Авсан оноо	Үнэлгээний хэлбэр
1	Тусламж, үйлчилгээний холбоотой зорилтот болон төлөвлөгөөт хяналт, үнэлгээ Төрийн хяналтын байгууллагын хяналт, үнэлгээ	Удирдамж, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж	1	1	Дүгнэлт, зөвлөмжтэй
2	шатны байгууллагын явцын үнэлгээ, хөндлөнгийн чанарын Унэлгээ,	Лабораторийн чанарын гадаад үнэлгээнд "амжилттай" хамрагдсан байх	тайлан, бүхий, зөвлөмж "хангалттай" авсан байх	1	тайлан, чанарын Унэлгээ
3	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хяналт, Унэлгээ чанарын Унэлгээ	Санхүү, санхүүжилтийн зарцуулалтад хийсэн хяналт, Унэлгээ	1	1	
4				5	
5					

Бүлгийн нийт оноо (D)

Хүснэгт 4. Нэмэлт үзүүлэлт- ӨЭМТ-ийн Үйл ажиллагааны онцгойлон сайн үнэлгэдэх үзүүлэлт

		Нэмэлт шалгуур	Шалгуур	Авч болох оноо	Авсан оноо	Үнэлгээний хэлбэр
1	ОУ-ЫН ЧАНАРЫН БАТАЛГАЖИЛТ	Үнэлгээний онд гэрчилгээ авсан бол		2		Гэрчилгээ, шалгалтын хяналт, дүн, дүгнэлт, зөвлөмжтэй тайлтан, танилцаж
2	ТӨРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ДҮН	Бага эрсдэлтэй үнэлгэдсэн бол		1		
3	САНХҮҮГИЙН АУДИТЫН ДҮН	Зөрчилгүй үнэлгэдсэн бол		1		
4	ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ГАДААД ХЯНАЛТ	“АМЖИЛГАЙ” ХАМРАГДСАН БАЙХ 80-ААС ДЭЭШ ҮНЭЛГЭЭ		1		
		БҮЛГИЙН НИЙТ ОНОО (D)		5		

Хүснэгт 5. Гэрээний биөлэлтийн үнэлгээний дүнгийн нэгтгэлийн загвар

Д/Д	Гайцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо	Үржулэх коэффициент	Нийт оноо
1	Өвөрмөч (A)-55%	<u>80</u>	<u>a</u>	<u>a/80 * 55</u>	<u>A</u>
2	Тусламж, үйлчилгээний үндсэн үзүүлэлт (B) 20%	<u>20</u>	<u>b</u>	<u>b * 1</u>	<u>B</u>
3	Нийтлэг (C) 20%	<u>20</u>	<u>c</u>	<u>c * 1</u>	<u>C</u>
4	Дээд шатны байгууллагын явцын үнэлгээний дүн (D) 5%	<u>5</u>	<u>d</u>	<u>d * 1</u>	<u>D</u>
5	Нэмэлт шалгуур (E)-5% • ОУ-ЫН чнаарын баталгаажилтын гэрчилгээ авсан бол • Төрийн хянант, шалгалаар бага ээрсдэлтэй үнэлэгдсэн бол • Санхүүгийн аудитад зөрчилгүй Унэлэгдсэн бол • Лабораторийн чанарын гадаад үнэлгээнд “амжилттай” хамрагдсан бол				E
	Нийт				Sum (A, B, C)

Үнэлгээний дүгнэлтийг зөвшөөрсөн:

Үнэлгээний багийн ахлагч:

Үнэлгээний багийн гишүүд:

/Гарын үсэг/
/Гарын үсэг/

Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга

Гарын үсэг/

Жишээ:

Хүснэгт 6. Гэрээний биелэлтийн үнэлгээний дүнгийн нэгтгэлийн загвар

№	Гүйцэтгэлийн шалтуур үзүүлэлт	Аббал зохих оног	Авсан оног	Үржүүлэх коэффициент	Нийт оног (%)
1	Өөвермөц (A) 55%	80	70	A=70/80*55	48.1
2	Туслахж, үйлчилгээний үндсэн узүүлэлт (B) 20%	20	16	B=16 * 1	16
3	Нийтлэг шалтуур (C) 20%	20	18	C=18 * 1	18
4	Дээд шатны байгууллагын явцын үнэлгээний дүн (D) 5%	5	3	D=3 * 1	3
5	Нэмэлт шалтуур (E) 5%				
	<ul style="list-style-type: none"> • ОУ-ын чанарын баталгаажилтын гэрчилгээ авсан бол • Төрийн хяналт, шалгалтаар бага эрдэлтэй үнэлгэдсэн бол • Санхүүгийн аудитад зөрчилгүй үнэлгэдсэн бол 			E=e*1	
				0	
				0	
				0	
				85.1	
	Нийт				

Үнэлгээний дүгнэлтийг зөвшөөрсөн:

Үнэлгээний багийн ахлагч:

Үнэлгээний багийн төвийн дарга:

/Гарын үсэг/

Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга

/Гарын үсэг/